

НИЙСЛЭЛ ХОТ ОРЧМЫН ТУСГАЙ СОНРХИОЛЫН АМРАЛТ, АЯЛЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

1.1.1. Нийгмийн эрэлт, хэрэгцээ

Тусгай сонирхолын аялагчид дэлхийн аялал жуулчлалын зах зээлийн 10 орчим хувийг эзэлж, аяллын тоо 2011 оноос 2012 онд 24.4 өсөж 72.3 хуьд хүрч¹, нас, хүйс, ажил, мэргэжил, нийгэм, соёлын ялгааг үл харгалзан өсөн нэмэгдэх хандлагатай байна.²

Хот хүний аж амьдрал, дасан зохицохуйд эдийн засаг, нийгэм, ахуй, соёлын хэрэгцээг хангахын сацуу байгалиас холдуулж, экологийн таагүй нөлөө үзүүлж байна. Хотжилт нь амралт, аяллын эрэлтийг нэмэгдүүлж, шинэчлэлийг даган өөрчлөгдөж байна. Оршин суугчид хот доторхи хэвшмэл амралтаас бусад шинэ зорилго, агуулатай тусгай сонирхолын амралт, аяллын төрлийг (цаашид ТСАА гэнэ) сонирхох болов. ТСАА нь масс амралт, аялалтай харьцуулахад эхлэлийн хөрөнгө бага шаарддаг, байгалийн унаган тогтоц, түүх соёлын нөөцийг ихэвчлэн тэр хэвээр ашиглаж³ байна.

100000 оршин суугчтай хотын хүн амын 50.0, 200000 оршин суугчаас 55.0, 1000000 оршин суугчаас 56.0 хувь нь хотоос гарч амардаг⁴, 11000-50000 хүн амтай бол 15.0-17.0 хувь, 100000-150000 бол 18.0-22.0, 200000-250000 бол 23.0-35.0, 250000-300000 бол 28.0-30.0, 300000-с их бол 35.0-40. хувь нь хотоос гарч амардаг⁵ гэвэл 2013 оны байдлаар Улаанбаатарын хүн амын 35.0-56.0 хувь буюу 473.6-757.9 мянган хотоос гарч амарч байна гэсэн үзүүлэлт харагддаг.

Амрагч, аялагчид байгальтай харьцах, соёлтой харьцах, биеийн хүчний оролцоо зэрэг агуулгаас дурын хоёрыг сонирхдог⁶, бүс нутгийн эдийн засаг, экологийн, соёлын хүчин зүйлийг тэнцвэртэй⁷ байлгадаг нь ТСАА-ын онцлогыг идэрхийлдэг олон улсад жишиг нэгэнт тогтжээ.

Төв аймгийн ТСАА-ын зорилтот зах зээл нь шашны аялалд оролцогсод, боломжит зах зээл нь хотын аялал бөгөөд дамжин өнгөрөгсөд, хотын оршин суугчид үндэсний зах зээлийн 27 хувийг эзэлж, Улаанбаатарын тусгай сонирхлын аялалын бүтээгдэхүүнийг хөгжүүлэх нөөцөд 78 төрлийн амралт, аяллыг төрөлжүүлэн хөгжүүлэх боломжтой гэж үзсэн байна.⁸ Түүнчлэн экологийн мэдлэг олох зорилгоор унаган болон зохиомол байгаль ажиглах, гоо сайхны болон сэтгэл ханамж авах зорилгоор байгальд амрах, байгалийн хүчин зүйлийг хэрэглэн эрүүлжих, адал явдал хайх болон спортын зорилгоор жилд 8000-17000 жуулчин Горхи тэрэлжийн байгалийн цогцолборт газар, Хагийн хар нуур, Богд хаан уул, Туул гол, Ар өвөр Жанчивланд амарч байна.⁹

Улаанбаатар бүсийн тусгай сонирхлын аялал жуулчлалд ашиглагдаж байгаа үндсэн нөөцийг 1. эртний болон одоогийн хөгжил дэвшил, 2. төрөл бүрийн музей үзэх, 3. хотын байдалтай танилцах, 4. хурал зөвлөлгөөн, бизнесийн уулзалт зохион байгуулах, 5. хотын ойролцоох үзэсгэлэнт онгон байгаль, 6. эртний түүх,

¹ ATTA, 2012 Adventure Travel Trade Association, <http://www.adventuretravel.biz/>

² <http://www.rae.ru/forum2012/184/123>

³ Drita Kruja, Albana Gjyrezi, The Special Interest Tourism Development and the Small Regions. TURIZAM. Volume 15, Issue 2 77-89 (2011)

⁴ Агапова А.Б. - Особенности территориального управления в пригородных зонах крупнейших городов мира. <http://geopub.narod.ru/02.24.2008/>

⁵ Мироненко Н.С., И.Т. Твердохлебов. Рекреационная география. МГУ. 1981. стр. 77.

⁶ Adventure Travel Trade Association, The George Washington University, and Xola. (2011). Adventure Tourism Development Index 2010. Report. Seattle, WA.

⁷ ATDI

⁸ "Тусгай сонирхлын аялал жуулчлалын нэр төрөл, бүтээгдэхүүн, чиглэлийг тодорхойлох судалгаа, төлөвлөлт" 2012-2016 он. ССАЖЯ.

⁹ Аялал жуулчлалын онцгой сонирхолын дэд бүсийн байгалийн нөөцүүд. "Тусгай сонирхлын аялал жуулчлалын нэр төрөл, бүтээгдэхүүн, чиглэлийг тодорхойлох судалгаа, төлөвлөлт" 2012-2016 он. ССАЖЯ. 52-р тал

соёлын дурсгалт зүйл¹⁰ хэмээн тэмдэглэжээ. АНУ-д үндэсний хэмжээнд зугаалга, жолоодлого, усан сэлэлт, танилцах, явган алхаа, спортын тоглоом, загасчлал, спортын арга хэмжээ үзэх, завин аялал, дугуйн аяллыг хамгийн түгээмэл гэдэг бол каное, унадаг дугуй, спортын арга хэмжээ үзэх, кэмпинг, усан онгоц, завины аялал, уулын авиралт, явган алхаа, усны цанын төрөл хамгийн эрчимтэй хөгжиж байна¹¹ гэжээ.

Веб сайтаар 38 тур операторууд аяллын нөхцөл, нөөц хүрэлцээтэй, ирээдүйтэй гэсэн зарчмаар тусгай сонирхолын 24 нэр төрлийн бүтээгдэхүүнийг гадаад зах зээлд борлуулах санал дэвшүүлж байна. Үүнд:

- Агуйн аялал, ан агнуурын аялал, баяр үзэх, нохой чарганы аялал, судалгааны аялал, угсаатны аялал, хаданд авирах аялал, шүхэрээр буух аялал, эмчилгээ сувилалын аялал тус бүр 1,
- Гэрэл зураг, моторт дугуйн аялал, сэлүүрт завиар зугаалах, цэцэг судлах аялал, шашины аялал давхардсан тоогоор тус бүр 2(5.3 хувь),
- Авто аялал, амьтан судлах давхардсан тоогоор тус бүр 3 (7.9 хувь),
- Тэмээн аялал давхардсан тоогоор тус бүр 4 (10.5 хувь),
- Бартаат аялал, уулын аялал давхардсан тоогоор тус бүр 6 (15.8 хувь),
- Дугуйн аялал, явган аялал давхардсан тоогоор тус бүр 7 (18.4 хувь),
- Шувуу ажиглах аялал давхардсан тоогоор дангаараа 9 (23.7 хувь),
- Загасчлах аялал давхардсан тоогоор дангаараа 12 (31.6 хувь),
- Морин аялал давхардсан тоогоор дангаараа 21 (55.3 хувь).

2013 оны статистик мэдээллээр нийслэлд аялал жуулчлал, зочлох үйлчилгээний салбарт 16498 хүн ажиллаж, эдийн засгийн 9.8 хувийг эзэлж байна. 2008 онд оршин суугчид дунд явуулсан судалгаагаар Налайхд 42.6 хувь, Сүхбаатар дүүргийн 1-р хороонд 73.4 хувь, Баянгол дүүргийн 8-р хороонд 59.8 хувь салхинд гарах сонирхолтой байгаа нь хотын төвийн оршин суугчид экологийн цэвэр орчинд амрах сонирхол өндөр болохыг харуулав. Хотын оршин суугчдын амралт, чөлөөт цагийн ерөнхий төлөв байдал, хот орчмын амралтын газруудын үйлчилгээний чанарыг тодорхойлох зорилготой 2014 оны судалгаанд хамрагдагсдын тал буюу 50.0 хувь нь долоо хоногийн амралтын өдрүүдийг гэртээ өнгөрөөхийг, 30.0 хувь нь хөдөө салхинд гарахыг илүүд үзжээ. Насны ангиллын хувьд залуучуудын ихэнх нь хотоос гадагш салхинд гарах сонирхолтой байв. Эмэгтэйчүүдийн 31.0 хувь, эрэгтэйчүүдийн 28.6 хувь салхинд гардаг гэсэн байдаг. Хотын оршин суугчдын байгалийн амралтаа өнгөрүүлэх дуртай орон зай Горхи-Тэрэлж, Богд хан уул, Хандгайт, Сонгино, Сэлбэ, Гачуурт, Толгойт гэсэн эрэмбэтэй байна. Амрагчдын 28.6-31.0 хувь байгалийн ландшафтын бүрдлийг, 9.5-27.6 хувь амралтын газрын тохижилт, 13.8-14.3 хувь үнэ тарифыг голлон анхаардаг болох нь ажиглагдав. Амралтын газруудын 66 буюу 36.1 хувь нь ойг, 36 буюу 19.7 хувь боржин чулууны тогтцыг, 34 буюу 18.6 хувь голыг, 22 буюу 12.0 хувь уул, толгодыг, 14 буюу 7.7 хувь тал хээрийг, үлдэх 11 буюу 6 хувь нь элс, рашаан, амьтныг түшиц нөөцөөр сонгосон явдал нь ой модыг ТСАА-ын чухал нөөц гэж үзэж байв. Хотын оршин суугчид хотоос гадуурх амралт, аялалд нэн сонирхолтой. Хүснэгт № 1.

¹⁰ Аялал жуулчлалын онцгой сонирхолын дэд бүсийн байгалийн нөөцүүд. “Тусгай сонирхлын аялал жуулчлалын нэр төрөл, бүтээгдэхүүн, чиглэлийг тодорхойлох судалгаа, төлөвлөг” 2012-2016 он. ССАЖЯ. 82-р тал

¹¹ Recreation needs assessment. Section 5. State and national assessment. Catawda County, North Carolina. Comprehensive Parks Plan 2007-2017. <http://www.catawbacountync.gov./14.02.2008/>. p –V-19.

Хүснэгт № 1. Хотын оршин суугчдын ТСАА-ын сонирхол

	Биеийн тамирын амралт, аялал	Соёлын амралт, аялал	Эрүүл мэндийн амралт, аялал
Олон сонголттой амралт аялал	<ul style="list-style-type: none"> • Авто машинтай аялал • Явган аялал • Дугуйн аялал • Байгууллагын зугаалга 	<ul style="list-style-type: none"> • Байгаль экологийн аялал • Малчин ахуйтай танилцах аялал 	<ul style="list-style-type: none"> • Хуурай уур амьсгалын амралт • Чийглэг уур амьсгалын амралт
Сонирхолтой амралт, аялалд	<ul style="list-style-type: none"> • Морин аялал • Уулын авиралт • Голын идэвхтэй амралт • Нохой чарга, авто чарга 	<ul style="list-style-type: none"> • Сургалт судалгааны аялал • Самар жимс түүх аялал • Түүх дурсгалын аялал • Амьтан, шувуу судлах аялал • Ландшафт сэргээх аялал 	<ul style="list-style-type: none"> • Ойн уур амьсгалын амралт • Зуслангийн гэр бүлийн амралт
Эрсдэлтэй амралт аялал	<ul style="list-style-type: none"> • Авто, мото уралдаан • Уулын цана, чарганы гулгалт • Агаарын болон өндрөөс буух 	<ul style="list-style-type: none"> • Загасчлал • Баяр, наадам үзэх 	<ul style="list-style-type: none"> • Голын эрэг хөвөөний амралт

Нийслэлийн хэмжээнд нийт 56 төрлийн спортын мэргэжлийн тамирчдын 56.5 хувийг бялдаржуулах, сагсан бөмбөг, гар бөмбөг, хөл бөмбөгийн тамирчид эзэлж байгаа ба үлдэх 43.5 хувь буюу 52 төрөлд 4-876 тамирчин хамрагдаж байна. 2008 оноос 2013 онд спортоор хичээллэгсдийн тоо 28313-20331, биеийн тамираар хичээллэгсдийн тоо 139768-200819 болж өөрчлөгджээ.¹² Улаанбаатарт 4 цанын бааз, 11 усан бассейн, 719 тоглоомын ил талбай, 194 спортын битүү танхим, 2 цэнгэлдэх хүрээлэн, 38 мөсөн гулгуурт нийт 619286 хүний багтаамжтай байна. 2013 онд 651.0 мянган хүнийг хамарсан 119 дугуйлан, 240 тэмцээн, 59 сургалт, семинар, 135 сурталчилгаа, 484 нийтий арга хэмжээ зохион байгуулжээ.

2013 онд мэргэжлийн спортоор хичээллэгсэд 20331 байгаагаас 79.7 хувь (16211) 34 хүртэл насны, 74.3 хувь нь эрэгтэйчүүд байна. Арван тамирчин тутмын 4 (37.2 хувь, 7570) бялдаржуулах спорт, арван хоёр тамирчин тутамд 1 хүн (7.9 хувь, 1601) нь сагсан бөмбөг, арван тав тутамд 1 хүн (6.4 хувь 1310) нь гар бөмбөг, хорь тутамд нэг хүн 5.0 хувь (1009) нь хөл бөмбөгөөр хичээллэж байна.

ССАЖЯ-ны 2012 оны “Тусгай сонирхлын аялал жуулчлалын нэр төрөл, бүтээгдэхүүн, чиглэлийг тодорхойлох судалгаа, төлөвлөлт”-ийн баримт бичигт Улаанбаатар хотод жуулчны төвийг байгуулах аялалын мэдээллийн томоохон баазыг байгуулах, 2. Аялалын зам маршрутыг тусгай сонирхолын аялалын бүсээр

¹²Монгол улсын статистикийн эмхтгэл. УСХ. УБ 2009, 2014

төрөлжүүлэн төлөвлөх, 3. Зам дагуу сүлжээний хоолны газар амрах байруудыг бий болгох зэрэг арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр тусгажээ.

1.1.2. ТСАА-ын нөөцийн бүсчлэл

Амралт, аялал жуулчлалын орон зайн бүсийн хилийг тогтооход газарзүйн аль нэг хилийг сонгох нь учир дутагдалтай гэж үзэв. Иймд нутаг дэвсгэрийн амралт, аялал жуулчлалын нөөц ашиглалтын өнөөгийн хэлбэр, бодит байдал, ирээдүйн хандлагыг төсөөлөн, ерөнхий газарзүйн зарчимд тулгуурлан амралт, аялал жуулчлалын орон зайн хилийн зааг, ялгарлыг тогтоохдоо:

1. Амралт, аялал жуулчлалын байгаль, түүх соёл, нөхцөл нөөцийн тархалт,
2. Амралт, аялал жуулчлалын үйлчилгээний газруудын байршилт,
3. Ландшафт, тусгай хамгаалалттай газар, усны ай савын¹³ хил хязгаар,
4. Нийгэм-эдийн засаг, амралт, аялал жуулчлалын таталцалын орон зайн хүрээ,
5. Зам харилцаа, засаг захиргааны нэгжүүдийн хил зэргийг давхцуулан үзэв.

Нийслэл орчмын амралт, аялал жуулчлалын орон зай гурван хүрээнээс бүрдэх ба эхний хүрээ буюу дотоод бүс 7670.0 км² нутаг дэвсгэрийг хамрах бөгөөд энд хүн амын суурьшил, үйлдвэрлэл, хөдөө аж ахуй, мал аж ахуй, амралт, аялал жуулчлалын аж ахуй холилдсон, хамгийн их үүрэгтэй, ачаалалтай орон зай юм. Нэг үгээр холимог аж ахуйн бүс гэж тодорхойлж болно. Дотоод бүсийн орон зайг 10 дэд бүс, 32 бичил бүсэд хуваав. Хоёр дахь хүрээ буюу завсрын бүсийг /28656.0 км²/ 6 дэд 18 бичил бүсэд, гуравдугаар буюу захын бүсийг /43022.0 км²/ 5 дэд, 11 бичил бүсэд хувааж бичил бүсүүдийн амралт, аялал жуулчлалын болон түүнтэй холбоотой дэд бүтцийн нөхцөл байдалд үнэлгээг хийх зорилгоор таксоныг гаргав. Хүснэгт № 2.

ТСАА-ын бүсүүдийн гадаргын хотгор гүдгэр (үнэмлэхүй өндөр, өндөр ба талбайн харьцаа, харьцах дээд өндөр, хэрчигдэл), гадаргын хэв шинж (хэв шинжийн хослол, тоо, нягтралын коэф.), ойн сангийн тархалт, байгалийн бүс, бүслүүр (ойн сангийн тархалт, байгалийн бүс, бүслүүрт хамрагдах байдал), ландшафт (хэв шинжийн тархалтын тоо, нягтрал), ургамлын нөмрөг (ургамлын нөмрөгийн хослол), усны нөхцөл, нөөц (нуурын тархалт, гадаргын усны сүлжээ, рашааны тархалт, ашиглалтын хүрээ), уур амьсгал (агаарын жилийн дундаж температур, үнэмлэхүй их температур, үнэмлэхүй бага температурын, хур тунадасны жилийн нийлбэр, бүрхэг өдрийн тоо, жилд нар гийгүүлэх хугацаа, цасан бүрхүүлтэй хоног), зам харилцааны дэд бүтцийн нөхцөл (замын зардал, УБ-с алслагдах зай, замын төрөл, авто замын нягтрал), аж ахуй эрхлэлтийн хэлбэр, хүн амын суурьшил, ашиглалт хамгаалалтын байдал (суурьшлаас тусгаар байдал,

¹³ Бэлчээр, усны нөөц, ой, хамгаалалт, аялал жуулчлалын хэрэглээг хангах даац голын сав газрын хүчин зүйлээс шалтгаалж өөр өөр байдаг. Хураангуй ба зөвлөмж. Монгол улсын анхаарч ажиллах чиглэл. Монгол улсын эдийн засаг, экологийн эмзэг байдал ба хүний аюулгүй байдлын судалгаа. УБ.2005. 17-р тал.

газар нутгийн хамгаалагдсан байдал, антропоген хотгор гүдгэр), түүх, соёлын объект (нийтийн үзвэр, зугаацлын томоохон объект, түүх, соёлын объектын ач холбогдол), амралтын газрын сүлжээ (амралтын газрын тоо, нягтрал, ор, төрөлжилт) зэрэг 39 шалгуур үзүүлэлтээр цогц үнэлгээ хийснээр бичил бүсүүдийн ТСАА-ын орон зайн ялгааг тогтоож, ангилал хийв. Хүснэгт № 2, 3. Зураг № 1.

Хүснэгт № 2. ТСААН-ын үнэлгээ

Дэд бүсийн талбай, км ² , эзлэх хувь	Бичил бүс	Бичил бүсийн дугаар	ТСАА-ын нөхцөлийн оноо	ТСАА-ын тааламжийн эрэмбэ
Улаанбаатарын 1030.0 /13.4/	Толгойт-Баян голын	1.1	64	Харьцангуй тааламжтай
	Ар Гүнтийн	1.2	49	Тааламж муутай
	Баян-Сэлбийн	1.3	69	Харьцангуй тааламжтай
	Улиастайн	1.4	51	Тааламж муутай
Баян зүрхийн 545.0 /7.1/	Гачууртын	2.1	56	Тааламж муутай
	Баянзүрхийн	2.2	60	Тааламж муутай
	Арцатын	2.3	49	Тааламж муутай
Горхийн 310.0 /4.0/	Туулын	3.1	68	Харьцангуй тааламжтай
	Горхийн	3.2	60	Тааламж муутай
	Тэрэлжийн	3.3	66	Харьцангуй тааламжтай
Жанчивлангийн 020.0 /13.3/	Цонжин Болдогийн	4.1	68	Харьцангуй тааламжтай
	Жанчивлангийн	4.2	62	Харьцангуй тааламжтай
	Нагал Ханы	4.3	68	Харьцангуй тааламжтай
	Нагал Хан БНГ	4.4	59	Тааламж муутай
Зуун Модны 720.0 /9.4/	Сэргэлэнгийн	5.1	51	Тааламж муутай
	Тахилтын	5.2	62	Харьцангуй тааламжтай
	Өлзийт-Түргэний	5.3	60	Тааламж муутай
Богд ханы 425.0 /5.5/	Туулын ай савын	6.1	82	Тааламжтай
	Хөлийн голын	6.2	77	Тааламжтай
	Хустайн давааны	6.3	76	Тааламжтай
Алтанбулагийн 745.0 /9.7/	Сонгины	7.1	66	Харьцангуй тааламжтай
	Таван толгойн	7.2	66	Харьцангуй тааламжтай
	Өвөр Хөшөөтийн	7.3	69	Харьцангуй тааламжтай
Хустайн нурууны 450.0 /5.9/	Алтанбулагийн	8.1	54	Тааламж муутай
	Баянхангайн	8.2	63	Харьцангуй тааламжтай
	Аргалантын	8.3	55	Тааламж муутай
Аргалантын 910.0 /11.9/	Жирмийн хөндийн	9.1	60	Тааламж муутай
	Ар Дулааны	9.2	52	Тааламж муутай
	Молцог элсний	9.3	58	Тааламж муутай
Баянчандманы 1515.0 /19.8/	Хайрт хааны	10.1	57	Тааламж муутай
	Согоотын	10.2	59	Тааламж муутай
	Партизаны	10.3	53	Тааламж муутай
Мандалын 2801.0 /9.8/	Үдлэг-Сөгнөгөрийн	1.1	62	Харьцангуй тааламжтай
	Баян Буурлын	1.2	62	Харьцангуй тааламжтай
	Бургалтайн	1.3	50	Тааламж муутай
Тэрэлж БЦГ-ын 4916.0 /17.2/	Заан-Тэрэлжийн	2.1	57	Тааламж муутай
	Туул-Тэрэлжийн	2.2	70	Харьцангуй тааламжтай
	Хагийн хар нуурын	2.3	62	Харьцангуй тааламжтай
Эрдэнэ – Ар Хустын 4481.0 /15.7/	Баяндэлгэрийн	3.1	68	Харьцангуй тааламжтай
	Бөөрөлжүүтийн	3.2	67	Харьцангуй тааламжтай
	Багахангайн	3.3	48	Тааламж муутай

Мааньт-Шархайн 7606.0 /26.7/	Мааньтын	4.1	54	Тааламж муутай
	Шархайн хөндийн	4.2	47	Тааламж муутай
	Туулын	4.3	50	Тааламж муутай
Баян Хангай-Лүнгийн 4976.0 /17.4/	Туулын тохойн	5.1	53	Тааламж муутай
	Энхийн хөндийн	5.2	52	Тааламж муутай
	Цэгээн нуурын	5.3	49	Тааламж муутай
Баянцогт-Дугана Хадны 3771.0 /13.2/	Баян цогтын	6.1	46	Тааламж муутай
	Жаргалантын	6.2	49	Тааламж муутай
	Борнуурын	6.3	60	Тааламж муутай

Хүснэгт № 3. ТСАА-ын орон зай¹⁴

Дэд бүс /10/	Бичил бүс /31/	ТСАА-ын орон зайн гурвал томъёолол
Улаанбаатарын	Толгойт-Баян голын	3Us, 3Fs, 3Ms
	Ар Гүнтийн	3As, 3Ls
	Баян-Сэлбийн	3Ds, 3Fs, 3Us, 3Rs
	Улиастайн	3Ls, 3Ps, 3Ss, 3Ts ¹
Баян зүрхийн	Гачууртын	3Cs, 3Ls, 3Ss, 3Ts ¹
	Баянзүрхийн	3Es, 3Ss
	Арцатын	3Ls, 3Ps
Горхийн	Туулын	3Ms, 3Ss, 3Ts
	Горхийн	3Ds, 3Ms,
	Тэрэлжийн	3Cs, 3Ds, 3Ms, 3Rs
Жанчивлангийн	Цонжин Болдогийн	3Ns, 3Ms
	Жанчивлангийн	3Ds, 3Ss ³ , 3Us
	Нагал Ханы	3Cs, 3Ls, 3Ps, 3Ss ³
	Нагал Хан БНГ	3Ps, 3Fs
Зуун Модны	Сэргэлэнгийн	3Ls, 3Rs, 3Us
	Тахилтын	3Cs, 3Ls
	Өлзийт-Түргэний	3As, 3Cs, 3Us
Богд ханы	Туулын ай савын	3Ms, 3Ps, 3Ts ¹
	Хөлийн голын	3Ps, 3Ts, 3Ts ¹
	Хустайн давааны	3Cs, 3Ps, 3Ts, 3Ts ¹
Алтанбулагийн	Сонгины	3As, 3Ds, 3Ms, 3Rs,
	Таван толгойн	3As, 3Cs, 3Ds, 3Ls
	Өвөр Хөшөөтийн	3Cs, 3Ls, 3Ps
Хустайн нурууны	Алтанбулагийн	3Ps
	Баянхангайн	3Ps
	Аргалантын	3Ps
Аргалант	Жирмийн хөндийн	3Ls, 3Ns, 3Ts
	Ар Дулааны	3Cs, 3Ls,
	Молцог элсний	3Cs, 3Ss ² , 3Ts
Баянчандмань	Хайрт хааны	3As, 3Cs, 3Ls
	Согоотын	3As, 3Ls, 3Ts,

¹⁴3As- цэвэр агаарт ногооны аж ахуй эрхлэх орон зай /Active, Air, Agro/

3Cs- хөдөөгийн малчдын бүлгийн аж төрөх соёлын орон зай /Countryside, Culture, Community/

3Ds- хүний үйл ажиллагаанаас доройтсон, гамшигт хүрсэн орон зай /Disastrous, Diclne, Degraded/

3Es- танин мэдэхүй, спорт аялал, экологийн орон зай /Extrim, Eco, Education/

3Fs- зуны зуслангийн орон зай /Family, Forest, Fair/

3Ls- байгаль, аж ахуйн танилцах амралт, аяллын орон зай /Landscape, Livestock, Leisure/

3Ns- зон олны наадам, зугаацлын орон зай /Nature, Native, Naadam/

3Ms- хүн машины хөл дарсан нийтийн амралтын орон зай /Mass, Mix, Moto/

3Ps- хамгаалалттай газрын экологийн амралтын орон зай /Protect, Park, Primitive/

3Rs- газар ашиглалтын шинэ орон зай орон зай /Reglaments, Rehouse, Remake/

3Ss¹- эмзэг мэдрэмжтэй эрүүл ахуйн орон зай орон зай /Sanitary, Standard, Sense/

3Ss²- зуны хээр тал нутаг орон зай /Sun, Steppe, Sand/

3Ss³- зуны хээр тал, элсний амралт орон зай /Spa, Steppe, Sun/

3Ts- амралтаар дайран өнгөрөх гуравдагч орон зай /Transit, Tertiary, Touring/


3Ts- тойрон аяллын ногоон бүсийн орон зай /Timberland, Tent, Touriad/

3Us- үзэмжгүй суурин газрын орон зай /Urbane, Unattractive, Used/

3Fs- алс байрлах хамгаалалттай орон зай /Fix, Far-off, Future/

	Партизаны	3As, 3Cs, 3Ls
Мандалын	Үдлэг-Сөгнөгөрийн	3As, 3Es, 3Ls, 3Ps, 3Ts ¹ , 3Fs
	Баян Буурлын	3As, 3Es, 3Ps, 3Ts ¹ , 3Fs
	Бургалтайн	3As, 3Ls
Тэрэлж БЦГ-ын	Заан-Тэрэлжийн	3Es, 3Ps, 3Ts ¹ , 3Ss
	Туул-Тэрэлжийн	3Cs, 3Es, 3Ls, 3Ps, 3Ts ¹ , 3Ss
	Хагийн хар нуурын	3Es, 3Ps, 3Ts ¹ , 3Fs
Эрдэнэ - Ар Хустын	Баяндэлгэрийн	3Cs, 3Ls, 3Ss ³
	Бөөрөлжүүтийн	3Ls
	Багахангайн	3Ls
Мааньт-Шархайн	Мааньтын	3Ls
	Шархайн хөндийн	3Ls, 3Ts
	Туулын	3Ls
Баян Хангай - Лүнгийн	Туулын тохойн	3Ls
	Энхийн хөндийн	3Ls, 3Ss ²
	Цэгээн нуурын	3Ls, 3Ss ² , 3Ts
Баянцогт -Дугана Хадны	Баян цогтын	3As, 3Cs, 3Ls
	Жаргалантын	3As, 3Cs, 3Ls
	Борнуурын	3As, 3Ds, 3Ls

Зураг № 1. Амралт, аялал жуулчлалын нутаг дэвсгэрийн бүсчлэл



Дотоод бүсийн газрын амралт, аялал жуулчлалын нөхцлийн итгэлцүүрийн дундаж 1.36, завсрын бүсийн дундаж 1.24, захын бүсийн дундаж 1.32, бүсийн хэмжээний дундаж 1.31 гарч байна. Бүсүүдийн амралт, аялал жуулчлалын нөхцлийн итгэлцүүрийн их утга 1.82 (Туулын ай савын бичил бүс), бага утга 1.0 (Шархайн хөндий, Баянцогтын бичил бүс), харин дотоод бүс дотроо хамгийн их утга нь 1.82 (Туулын ай сав), бага нь 1.09 (Ар Гүнтийн, Арцатын), завсрын бүсийн их утга нь 1.56 (Туул-Тэрэлжийн бичил бүс), бага утга 1.0 (Баянцогтын бичил бүс), захын бүсийн их утга нь 1.51 (Мөнгөн Морьтын бичил бүс), бага нь 1.13 (Батхааны БНГ-ын бичил бүс) байна.

Амралт, аялал жуулчлалын нөхцөлийн итгэлцүүрээр математик дундаж нь 1.3 байгаа ба уг интервалыг бүсийн дундаж үзүүлэлтээр авч түүнээс дээш үзүүлэлтийг хоёр ангилалд хувааж 1.0-1.3 байгалийн амралт, аялал жуулчлалд тааламж муутай орон зай, 1.35-1.52 харьцангуй тааламжтай, 1.65-1.78 тааламжтай гэсэн үзүүлэлтээр бичил бүсүүдийг ангилав. Байгалийн амралт, аялал жуулчлалын зориулалтаар ашиглаж байгаа газрын төлбөрийг тухайн тойргийн хамгийн ойр орших хот, тосгон, бусад суурин газрын төлбөрийн хэмжээтэй адилтгаж тооцох¹⁵ тул бичил бүсийн амралт, аялал жуулчлалын газрын үнийг дээд тал нь 78.0 хувиар нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Бүсийн хэмжээнд амралт, аялал жуулчлалын тааламжтай орон зайгаар амралт, аялал жуулчлалын нөхцлийн дундаж 78.3 оноотой Богд ханы дэд бүс (425.0 км², бүсийн нутаг дэвсгэрийн 5.5 %) байгаа бөгөөд тааламж муутай орон зайн хамгийн доод 50.3 оноотой Мааньт-Шархайн дэд бүсээс 1.6 дахин илүү амралт, аялал жуулчлалын ач холбогдолтой байгаа нь тогтоогдов. Нийт нутаг дэвсгэрийн 45.6 хувь буюу 36174.0 км² нутаг дэвсгэр байгалийн амралт, аялал жуулчлалд харьцангуй тааламжтай бол 53.8 хувь 42644 км² нутаг дэвсгэр тохиромж муутай, үлдэх 0.5 хувь буюу 425.0 км² нутаг дэвсгэр тааламжтай гэсэн ангилалд хамрагдаж байна. Харьцангуй тааламжтай орон зайн ерөнхийдөө Хан Хэнтийн уулархаг бүс, Туул, Хэрлэн голын ай сав, аялал жуулчлалын Говийн болон Хангайн маршрутын дамжин өнгөрөх нутаг дэвсгэрт байрлаж байна. Харин шинээр ашиглаж болох орон зай нь Хэрлэн голын сав дагуух Баянгийн дэд бүс гэдэг нь тогтоогдов. Богд ханы дэд бүсийн нутаг дэвсгэрийн ашиглалтын асуудлыг тусгай хамгаалалттай газрын хуулийн хүрээнд шийдвэрлэх ёстой юм. Харин тааламж муутай бүсүүдэд амралт, аялал жуулчлалаас бусад аж ахуйн үндсэн үйл ажиллагааг голлон эрхэлж болно. Бүсийн хэмжээнд амралт, аялал жуулчлалыг хөгжүүлэх харьцангуй тааламжтай гэсэн үнэлгээ авсан нутаг дэвсгэрийн амралт, аялал жуулчлалын орон зайн төлөвлөлт, ашиглалт, зохион байгуулалттай холбоотой асуудлын тухай дараачийн бүлэгт дурьдаж байна.

Судалгааны орон зайд нийт нутаг дэвсгэрийн 0.91 хувь буюу 3 бичил бүсийн 720.0 км² талбайтай нутаг дэвсгэр амралт, аялал жуулчлалын тааламжтай, 45.5 хувь буюу 24 бичил бүсийн 36044.0 км² талбайтай нутаг дэвсгэр харьцангуй

¹⁵ Газрын төлбөрийн тухай. Монгол улсын хууль. 7.2.7 заалт. 1994.04.24.

тааламжтай, 53.6 хувь буюу 34 бичил бүсийн 42497.0 км² талбай бүхий нутаг дэвсгэр тааламж муутай гэсэн орон зайд хамрагдаж байна.

Хавсралт № 1. Бүсийн ТСАА-ын бүтээгдэхүүний нөөц

ТСАА-ын бүс		1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	Үндсэн ба нэмэлт амарлт аяллын төрлүүд	Түгээмэл төрлийн эрэмбэ
ТСАА-ын бүс		1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16		
	Чингэлтэйн бүс (Толгойт-Баян гол, Ар Гүнт, Баян-Сэлбэ,																		
	Баян зүрхийн бүс (Гачуурт, Баянзүрх, Арцат)																		
	Горхийн бүс (Туул, Горхи, Тэрэлж)																		
	Жанчивлангийн бүс (Цонжин Болдог, Жанчивлан, Нагал Хан,																		
	Зуун Модны бүс(Сэргэлэн, Тахилт, Өлзийт-Түргэн)																		
	Богд ханы бүс (Туулын ай сав, Хөлийн гол, Хустайн даваа)																		
	Алтанбулагийн бүс (Сонгино, Таван толгой, Өвөр Хөшөөт)																		
	Хустайн нурууны бүс(Алтанбулаг, Баянхангай, Аргалант)																		
	Аргалантын бүс (Жирмийн хөндий, Ар Дулаан, Молцог элс)																		
	Баянчандманы бүс (Хайрт хаан, Согоот, Партизан)																		
	Мандалын бүс (Үдлэг-Сөгнөгөр, Баян буурал, Бургалтай)																		
	Тэрэлж БЦГ-ын бүс (Заан-Тэрэлж, Туул-Тэрэлж, Хагийн хар																		
	Эрдэнэ – Ар Хустынбүс(Баяндэлгэр, Бөөрөлжүүт, Багахангай)																		
	Мааньт-Шархайн бүс (Мааньт, Шархайн хөндий, Туулын)																		
	Баян Хангай - Лүнгийнбүс(Туулын тохой, Энхийн хөндий,																		
	Баянцогт –Дугана Хадныбүс(Баянцогт, Жаргалант, Борнуур)																		
	Үндсэн ба нэмэлт амарлт аяллын төрлүүд																		
	Түгээмэл төрлийн эрэмбэ																		
Биеийн тамирын амралт, аялал																			
1	Авто чарганы аялал	-	-	Ү	-	-	Ү	Ү	-	-	-	-	Н	-	-	-	-	3/1	III
2	Авто машины уралдаан	-	-	-	Н	Ү	-	Н	-	Н	-	-	-	-	-	-	-	1/3	-
3	Голын идэвхтэй амралт	Н	Ү	Ү	-	-	Ү	-	-	-	-	-	-	-	-	-	-	3/1	III
4	Зүлэгт талбайн тоглоом	Ү	Н	Н	Н	Н	Н	Ү	-	-	-	-	-	-	-	-	-	2/5	-
5	Морин аялал	Н	Н	Ү	Н	-	Ү	Н	Ү	Н	-	-	Н	-	-	-	Н	3/7	III
6	Нохой чарганы аялал	-	Н	-	-	-	-	Ү	-	-	-	Ү	Ү	-	-	-	-	3/1	III
7	Мотоцикл ын уралдаан	-	Н	-	Н	Ү	-	Н	Ү	-	Н	Н	-	Н	-	-	-	2/6	-
8	Нуурын	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	Н	-	Н	-	0/2	-

	идэвхтэй амралт																		
9	Спорт явган аялал	Ү	Ү	Ү	Н	-	Ү	-	-	-	Н	Ү	Ү	-	-	-	Н	6/3	II
10	Хадны авиралт	-	Н	Ү	Ү	-	Н	-	-	-	-	Н	Н	-	-	-	Н	2/5	-
11	Цанын гүйлт	Ү	Н	-	-	-	-	-	-	-	-	Н	Н	-	-	-	Н	1/4	-
12	Хурдан морины уралдаан	-	-	-	-	Ү	-	Ү	Ү	-	-	-	-	-	-	-	-	3/0	III
13	Уулын авиралт	-	Ү	Н	Н	-	Ү	Н	-	-	Н	Ү	Ү	-	-	-	Н	4/5	III
14	Уулын цана, чарганы гулгалт	Ү	Н	-	-	-	Ү	-	-	-	-	Н	Н	-	-	-	Н	2/4	-
15	Тэшүүрийн гүйлт	-	Н	-	-	-	Н	-	-	-	-	-	-	-	-	-	Н	0/3	-
16	Авто машинтай аялал	-	Н	Ү	Ү	Ү	Ү	Ү	Ү	Ү	Ү	Н	Н	Ү	Ү	Ү	Н	11/4	I
17	Агаарын бөмблөгтэй нислэг	-	-	-	-	-	-	-	-	-	Ү	-	-	-	Ү	Н	-	2/1	-
18	Агаарын уяатай үсрэлт	-	Ү	Н	-	-	Н	Н	-	-	Н	-	-	-	-	-	-	1/4	-
19	Байгууллагын зугаалга	Ү	Н	Ү	Н	Н	Ү	Н	-	-	-	-	-	-	-	-	Н	3/5	III
20	Дугуйт тавцангийн гулгалт	Н	-	Н	Н	-	Н	Ү	-	-	-	Н	-	-	-	-	-	1/5	-
21	Дугуйт тэшүүрийн гулгалт	Н	-	Н	Н	-	Н	Ү	-	-	-	Н	-	-	-	-	-	1/5	-
22	Дугуйн аялал	Ү	Ү	Ү	Н	Н	Ү	Ү	Ү	-	Н	Н	-	-	-	-	-	6/4	II
23	Задгай талбайн тэмцээн үзэх	-	-	-	Н	-	Ү	Ү	-	-	-	-	-	-	-	-	-	2/1	-
24	Нуурын сэлүүрт завины аялал	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	0/0	-
25	Голын загасчлал	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	Ү	-	-	-	-	1/0	-
26	Голын сэлүүрт завины аялал	-	Н	-	Н	-	-	-	-	-	-	Н	Ү	-	-	-	-	1/3	-
27	Усан сэлэлт	-	Н	Н	Н	-	Н	-	-	-	-	Н	Ү	-	-	-	-	1/5	-
28	Шүхрээр буух	-	-	Н	Н	Ү	-	-	-	-	Ү	Н	-	-	-	-	-	2/3	-
Соёлын амралт, аялал																			
1	Агро	-	-	-	-	-	-	-	-	-	Н	Ү	Ү	-	-	-	-	Ү	3/1

	аялал																			
2	Байгаль-экологийн аялал	Ү	Ү	Ү	Н	Н	Ү	Ү	-	Ү	Ү	Ү	Ү	-	Н	Н	Ү	10/4	I	
3	Өвлийн загасчлал	-	-	-	-	-	-	Ү	-	-	-	-	Ү	-	-	-	-	2/0	-	
4	Голын загасчлал	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	Ү	-	-	-	-	1/0	-	
5	Малчин ахуйн аялал	-	Н	Ү	Ү	Н	-	Ү	Ү	Ү	Ү	-	-	Ү	Ү	Ү	Н	9/3	II	
6	Морин чарганы аялал	-	Ү	Н	Н	-	-	Ү	-	-	-	Н	Ү	-	-	-	-	3/3	-	
7	Нуурын загасчлал	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	0/0	-	
8	Самар, жимс түүх аялал	Ү	Н	Ү	-	-	Н	-	-	-	Ү	Ү	Ү	-	-	-	Н	5/3	III	
9	Сургалт, судалгааны аялал	Н	Н	Ү	Н	Н	Н	Н	-	Ү	Ү	Ү	Ү	Н	Н	Н	Н	5/10	III	
10	Түүх, дурсгалын аялал	Н	-	Н	Ү	Ү	Н	Н	-	Н	Н	-	Н	Ү	Ү	Н	Н	4/9	-	
11	Хөдөөгийн тойрон аялал	-	-	Н	Н	-	-	Н	Ү	Ү	Ү	-	-	Ү	Ү	Ү	Н	6/4	III	
12	Авто уралдаан үзэх	-	-	-	-	Ү	-	Н	Ү	-	-	-	-	-	-	-	-	2/1	-	
13	Амьтан, шувуу судлах аялал	-	Н	Ү	Н	-	Ү	Н	-	Ү	Н	Ү	Ү	-	Н	-	Н	5/6	III	
14	Буудлагын тэмцээн үзэх	-	Н	-	Н	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	0/2	-	
15	Наадам үзэх	-	-	Ү	Н	-	-	Ү	Н	-	-	-	-	-	-	-	-	2/2	-	
16	Галт тэрэгний аялал	-	-	-	-	-	-	Н	-	-	-	Ү	-	Ү	-	-	-	2/2	-	
17	Ердийн хөсгийн аялал	-	Н	Н	Ү	-	-	Ү	-	-	Н	-	-	Н	-	-	Н	2/5	-	
18	Ландшафт сэргээх аялал	Ү	Н	Ү	Н	Н	Ү	Ү	-	Н	Н	Н	-	Н	-	Ү	Н	5/8	III	
19	Морин уралдаан үзэх	-	-	-	-	Ү	-	Ү	Н	-	-	-	-	-	-	-	-	2/1	-	
20	Мөсөн шагайн наадгай үзэх	-	-	-	-	-	Ү	-	-	-	-	Н	-	-	-	-	-	1/1	-	
21	Сэдэвчилсэн баяр үзэх	-	-	Н	Н	-	-	Н	-	-	-	-	-	-	-	-	-	0/3	-	
22	Урлагын	-	Ү	Н	Ү	-	-	Н	-	-	-	-	-	-	-	-	-	2/2	-	

	тоглолт, шоу үзэх																		
23	Хоол, хүнсний аялал	-	-	Н	Н	-	-	Н	-	-	Ү	Н	-	-	-	-	Н	1/5	-
24	Цас, мөсний тэмцээн үзэх	-	Н	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	0/1	-
25	Цэцэг ажиглах аялал	Н	Н	Н	Н	-	Ү	-	-	-	Н	Ү	Ү	-	-	-	Н	3/6	-
26	Шашны зан үйлийн аялал	Ү	-	-	Н	Ү	Ү	-	-	-	-	-	-	-	-	-	-	3/0	-
Эрүүл мэндийн амралт, аялал																			
1	Чийглэгүүр амьсгалта й амралт	Ү	Ү	Н	-	-	Ү	-	-	Н	Ү	Ү	Ү	-	-	-	Н	6/3	I
2	Голын эрэг хөвөөний амралт	Ү	Ү	Н	Ү	-	Ү	-	-	-	-	Н	Ү	-	-	-	-	5/2	II
3	Наран шарлага	Н	Н	-	Н	-	-	-	-	Ү	-	-	Н	Н	-	-	-	1/5	
4	Ойн уур амьсгалта й амралт	Ү	Ү	Н	-	-	Ү	-	-	Н	Н	Ү	Ү	Н	-	-	Н	5/5	II
5	Нуурын усны сувиллын амралт	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	Н	-	-	-	0/1	-
6	Хүйтэн рашааны сувилал	-	-	-	Ү	-	-	-	-	-	-	-	-	Ү	-	-	-	2/0	-
7	Шавар засалын амралт	-	-	-	Ү	-	-	-	-	-	-	-	-	Ү	-	-	-	2/0	-
8	Халуун рашааны сувилал	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	0/0	-
9	Хуурайуур амьсгалын амралт	Н	-	Н	Ү	Н	Н	Ү	Н	Ү	Н	-	-	Ү	Ү	Ү	Н	6/7	I
10	Элсний амралт	-	-	-	Ү	-	-	-	-	Ү	-	-	-	-	-	Ү	Н	2/1	
11	Эмчилгээн ий явган алхаа	Н	-	-	Ү	-	-	-	-	Н	-	-	-	Н	-	Н	-	1/4	-
12	Нуурын моторт завины аялал	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	0/0	-
13	Голын моторт завины аялал	-	Ү	Н	Н	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	1/2	-
14	Зуслангий н амралт	Ү	Ү	Н	-	Н	Н	-	-	-	-	-	-	-	-	-	-	2/3	-

Хавсралт № 2. Бүсийн ТСАА-ын төрөлжилтийн чиглэл

Бүсийн нэр	Тэргүүлэх төрөл	Дагалдах төрөл
1 Чингэлтэйн бүс (Толгойт-Баян гол, Ар Гүнт, Баян-Сэлбэ, Улиаст)	Зуслангийн амралт Зүлэгт талбайн тоглоом Спорт явганы аялал Цаны гүйлт, уулын цана чарга Дугуйн аялал	Байгаль эко Голын эрэг хөвөөний ланншафт сэргээх Шашны за үйл
2 Баян зүрхийн бүс (Гачуурт, Баянзүрх, Арцат)	Голын амралт Дугуйн аялал Байгаль эко,	Морин чарга Уулын авиралт Агаарын уяатай үсрэлт Моторт завь
3 Горхийн бүс (Туул, Горхи, Тэрэлж)	Байгаль эко Морин аялал Хадан авиралт	Амьтан шувуу ажиглах
4 Жанчивлангийн бүс (Цонжин Болдог, Жанчивлан, Нагал Хан, Нагал Хан БНГ)	Нийтийн амралт Хүйтэн рашаан, шавар эмчилгээ Ердийн хөсөг, авто аялал	Элсний эмчилгээ Хөдөөгийн аялал Түүх дурсгал, буудлага
5 Зуун Модны бүс (Сэргэлэн, Тахилт, Өлзийт-Түргэн)	Авто, мото морины уралдаан	Түүх дурсгал Шашны зан үйл
6 Богд ханы бүс (Туулын ай сав, Хөлийн гол, Хустайн даваа)	Явган алхаа Уулын авиралт Уулын цана, чарга Голын нийтийн амралт	Амьтан шувуу ажиглах Авто чарга Морин аялал Дугуйн бартаат аялал
7 Алтанбулагийн бүс (Сонгино, Таван толгой, Өвөр Хөшөөт)	Хурдан морины уралдаан Зүлэгт болон цардмал талбайн тоглоом Нохой чарга	Голын ландшафт сэргээх Амьтан шувуу ажиглах Өвлийн загасчлал Морин чарга
8 Хустайн нурууны бүс (Алтанбулаг, Баянхангай, Аргалант)	Хурдан морины уралдаан Дугуй, мото аялал	Хөдөөгийн аялал
9 Аргалантын бүс (Жирмийн хөндий, Ар Дулаан, Молцог элс)	Эко аялал Элсний амралт	Хөдөөгийн аялал
10 Баянчандманы бүс (Хайрт хаан, Согоот, Партизан)	Агро аялал Нийтийн амралт	Хөдөөгийн аялал Хоол хүнсний аялал
11 Мандалын бүс (Үдлэг–Сөгнөгөр, Баян буурал, Бургалтай)	Галт тэрэгний эко аялал Уулын явган аялал, авиралт Шүхэрээр буух Био аялал	Агро Эко аялал
12 Тэрэлж БЦГ-ын бүс (Заан-Тэрэлж, Туул-Тэрэлж, Хагийн хар нуур)	Явган аялал Голын загасчлал Завины аялал Нохой чарга	Эко аялал Био аялал Усан спорт Морин чарга
13 Эрдэнэ – Ар Хустынбүс (Баяндэлгэр, Бөөрөлжүүт, Багахангай)	Хүйтэн рашаан, шавар засал Галт тэрэгний аялал	Түүх, соёлын аялал Хөдөөгийн аялал
14 Мааньт-Шархайн бүс (Мааньт, Шархайн хөндий, Туулын)	Хөдөөгийн аялал	Агаарын бөмбөлөгтэй аялал

15	Баян Хангай - Лүнгийнбүс (Туулын тохой, Энхийн хөндий, Цэгээн нуур)	Хөдөөгийн аялал	Ландшафт сэргээх
16	Баянцогт –Дугана Хадныбүс (Баянцогт, Жаргалант, Борнуур)	Агро аялал Эко аялал	Нийтийн амралт Зан үйлийн амралт